

**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

ЗАГВАР ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын жолоочийн үнэмлэхийн загвар”-ыг нэгдүгээр, “Монгол Улсын олон улсын жолоочийн үнэмлэхийн загвар”-ыг хоёрдугаар, “Жолоочийн түр зөвшөөрлийн загвар”-ыг гуравдугаар, “Тээврийн хэрэгсэл жолоодох ангилал, дэд ангилалд хамаарах нэмэлт мэдээлэл болон хязгаарлалт”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.”Загвар батлах, тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/48 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Монгол Улсын жолоочийн үнэмлэхийн загварыг шинэчлэн баталсантай холбогдуулан иргэд, олон нийтэд хүндрэл учруулахгүйгээр одоогийн хэрэглэж буй жолоочийн үнэмлэхийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон болон нөхөж олгох тохиолдолд шинэ загварын үнэмлэхийг олгох хэлбэрээр зохион байгуулсугай.

4.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга (хошууч генерал Ж.Болд)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (П.Сайнзориг)-т тус тус даалгасугай.

САЙД

Х.НЯМБААТАР


Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР, НУУЦЛАЛ

А. Нүүрэн тал



Б. Ар тал




В. Хэт ягаан туяаны нууцлал



Г. Холограммын нууцлал



Д. Бүтэц, зохион байгуулалт



Монгол Улсын жолоочийн үнэмлэхийн загвар, нууцлал

Тээврийн хэрэгслийн жолоочийн үнэмлэхийн мэдээлэл нь цахим байдлаар агуулагдах олон улсын ISO/IEV 7810 ID-1 (85.60 x 53.98 mm) стандарт, чанарын шаардлага хангасан смарт (чип) картаар хийгдэнэ.

Жолоочийн үнэмлэхийн дэвсгэр нь мөнгөлөг саарал өнгөтэй, хэвлэлийн СМУК өнгөний #CCCBCB (C=31, M=24, Y=25, K=0) кодтой, төвөөс цацарсан хэлбэртэй, усан хээтэй байна. Нүүрэн талын голд “Бадамлянхуа цэцэг”-ийн суурин дээр “Төрийн соёмбо”, ар талын гол хэсэгт “Монгол Улс, Mongolia” гэсэн бичвэрийг Монгол Улсын газрын зурагт байршуулан, нүүрэн талын дээд, баруун талын арын хэсгийн дээд талд “ Жолоочийн үнэмлэх” гэсэн Монгол, Англи, Уйгаржин Монгол бичиглэлтэй байна.

Жолоочийн үнэмлэхийн мэдээлэл

Монгол Улсын нэгдэн орсон “Замын хөдөлгөөний тухай болон Замын дохио, тэмдгийн тухай” 1968 оны Венийн Конвенцийн дагуу дараах дугаарлалтаар мэдээллийг тусгана.

- 1.Эцэг (эх)-ийн нэр;
- 2.Өөрийн нэр;
- 3.Төрсөн огноо;
- 4.(a) Үнэмлэх олгосон огноо;
- 4.(b) Үнэмлэхийн хүчинтэй байх огноо;
- 4.(c) Үнэмлэх олгосон байгууллагын нэр;
- 5.Үнэмлэхийн дугаар;
- 6.Эзэмшигчийн зураг;
- 7.Эзэмшигчийн гарын үсэг;
- 9.Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн ангилал ба дэд ангилал;
- 10.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) тус бүрийн эрх олгосон огноо;
- 12.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) бүрд хамаарах нэмэлт мэдээлэл буюу хязгаарлалт зэрэг мэдээллийг Монгол, Англи хэл дээр тайлбарын хамт хэвлэнэ.

Нууцлал болон бусад мэдээлэл

Жолоочийн үнэмлэхийн зүүн дээд өнцөгт Монгол Улсын “Төрийн далбаа”, баруун дээд өнцөгт цэнхэр өнгийн дүрсэн дотор “MGL” гэсэн ялгах тэмдэг, ар талын баруун хэсэгт жолоочийн үнэмлэхэд агуулагдах мэдээллийн тайлбарыг Англи, Монгол хэлээр бичиж нүүрэн талд олон улсын QR code ашиглан цахим хэлбэрээр шалгах хаягийг тус тус тусгана.

Нүүрэн талд хэт ягаан туяаны тусгалд тодрох олон улсын шаардлагад нийцсэн холограммын нууцлалтай байна.

Жолоочийн үнэмлэхийн цахим чипэнд агуулагдах мэдээлэл

- 1.Эцэг (эх)-ийн нэр;
- 2.Өөрийн нэр;
- 3.Төрсөн огноо, регистрийн дугаар;
- 4.(a) Үнэмлэх олгосон огноо;
- 4.(b) Үнэмлэхийн хүчинтэй огноо;
- 4.(c) Үнэмлэх олгосон байгууллагын нэр;
- 5.Үнэмлэхийн дугаар;
- 9.Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн ангилал ба дэд ангилал;
- 10.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) тус бүрийн эрх олгосон огноо.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХИЙН ЭХ ЗАГВАР

1. Хавтасны нүүрэн тал



2. Дотор талын нүүрэн тал



3. Дотор талын хуудас /конвенц/



4. Дотор талын хуудас /конвенц/



5. Дотор тал /конвенц англи хэл/

CONVENTION ON ROAD TRAFFIC
(Vienna, 1968)

This document is not valid for driving on the territory of **MONGOLIA**.

It is valid for the territories of all the other Contracting Parties on condition that it is presented with the corresponding domestic driving permit. The categories of vehicles for which the permit is valid are stated at the end of the booklet.

LIST OF THE CONTRACTING STATES

Albania	Guyana	Portugal
Armenia	Hungary	Qatar
Austria	Iran	Maldiva
Azerbaijan	Israel	Romania
Bahrain	Italy	Russia
Belarus	Kazakhstan	San Marino
Belgium	Kenya	Senegal
Bosnia-Herzegovina	Kyrgyzstan	Serbia
Brazil	Latvia	Seychelles
Belgium	Liberia	Slovakia
Central African Republic	Lithuania	Slovenian
Cote d'Ivoire	Luxembourg	South Africa
Croatia	Republic of Macedonia	Sweden
Cuba	Mexico	Switzerland
Czech Republic	Montenegro	Tajikistan
Congo	Morocco	Tanzania
Denmark	Netherlands	Turkey
Estonia	Niger	Turkmenistan
Finland	Norway	Ukraine
France	Pakistan	United Arab Emirates
Georgia	Paraguay	Uruguay
Germany	Philippines	Uzbekistan
Greece	Poland	Vietnam
		Zimbabwe

This permit shall cease to be valid in the territory of another Contracting Party if its holder establishes his normal residence there.

6. Дотор тал /конвенц англи хэл/

The Contracting Parties, desiring to facilitate international road traffic and to increase road safety through the adoption of uniform traffic rules, have agreed upon the following provisions:

CHAPTER IV
DRIVERS OF MOTOR VEHICLES

ARTICLE 41
Driving permits

1. (a) Every driver of a motor vehicle must hold a driving permit;
(b) Contracting Parties undertake to ensure that driving permits are issued only after verification by the competent authorities that the driver possesses the required knowledge and skill;

2. Contracting Parties shall recognize:
(a) Any domestic permit drawn up in their national language or in one of their national languages, or, if not drawn up in such a language, accompanied by a certified translation;
(b) Any domestic permit conforming to the provisions of Annex 6 to this Convention; and
(c) Any international permit conforming to the provisions of Annex 7 to this Convention;

as valid for driving in their territories a vehicle coming within the categories covered by the permit, provided that the permit is still valid and that it was issued by another Contracting Party or subdivision thereof or by an association duly empowered thereto by such other Contracting Party. The provisions of this paragraph shall not apply to learner-driver permits.

6. An international permit shall be issued only to the holder of a domestic permit for the issue of which the minimum conditions laid down in this Convention have been fulfilled. It shall not be valid after the expiry of the corresponding domestic permit, the number of which shall be entered in the international permit.

7. Дотор тал /конвенц англи хэл/

PARTICULARS CONCERNING THE DRIVER

Family name: _____ 1.
Given name, other names: _____ 2.
Place of birth: _____ 3.
Date of birth: _____ 4.
Place of normal residence: _____ 5.

CATEGORIES AND SUBCATEGORIES OF VEHICLES, WITH THE CORRESPONDING CODES, FOR WHICH THE PERMIT IS VALID

Category code/Pictogram	Category code/Pictogram
A 	A1 
B 	B1 
C 	C1 
D 	D1 
BE 	
CE 	C1E 
DE 	D1E 

RESTRICTIVE CONDITIONS OF USE

8. Дотор тал /конвенц франц хэл/

INDICATIONS RELATIVES AU CONDUCTEUR

Nom: _____ 1.
Prénoms (ou autres noms): _____ 2.
Lieu de naissance: _____ 3.
Date de naissance: _____ 4.
Lieu de résidence normale: _____ 5.

CATEGORIES ET SOUS-CATEGORIES DE VEHICULES, AVEC LES CODES CORRESPONDANTS, POUR LESQUELS LE PERMIS EST VALABLE

Code de la catégorie/Pictogramme	Code de la catégorie/Pictogramme
A 	A1 
B 	B1 
C 	C1 
D 	D1 
BE 	
CE 	C1E 
DE 	D1E 

RESTRICTIONS A L'UTILISATION

9. Дотор тал /конвенц орос хэл/

ЗАПИСИ, ОТНОСЯЩИЕСЯ К ВОДИТЕЛЮ

Фамилия 1.
 Имя, отчество 2.
 Место рождения 3.
 Дата рождения 4.
 Общественное положение 5.

КАТЕГОРИИ И ПОДКАТЕГОРИИ ТРАНСПОРТНЫХ СРЕДСТВ УКАЗАНЫМ
СООТВЕТСТВУЮЩИМ КОДАМ, СЯ УПОМЯНУТЫЕ ВОДИТЕЛИ ИМЕЮТ
ПОСЛЕДОВАТЕЛЬНО

Номер категории / Категория	Иконка	Номер категории / Категория	Иконка
A		A1	
B		B1	
C		C1	
D		D1	
BE			
CE		C1E	
DE		D1E	

УСЛОВИЯ, ОГРАНИЧЕНИЯ И ДРУГОЕ УКАЗАНО

10. Дотор тал /конвенц герман хэл/

ANGABEN ZUR PERSON DES FUHRERS

Name 1.
 Vorname(n), anderer Name(n) 2.
 Geburtsort 3.
 Geburtsdatum 4.
 Beruflicher Status 5.

KATEGORIEN UND UNTERKATEGORIEN FÜR DIE DER FUHRERBEIHEBEN
GILT MIT DEN ENTSPRECHENDEN BEZEICHNUNGEN

Bezeichnung der Fahrzeugklasse / PK-Kategorie	Category code /PK-Kategorie
A	A1
B	B1
C	C1
D	D1
BE	
CE	C1E
DE	D1E

RESTRIKTIVE BEDINGUNGEN DER LIZENZ

11. Дотор тал /конвенц итали хэл/

INDICAZIONI RELATIVE AL CONDUCENTE

Cognome 1.
 Nome /di nomi 2.
 Luogo di nascita 3.
 Data di nascita 4.
 Gruppo di residenza attuale 5.

CATEGORIE E SOTTOCATEGORIE DI VEICOLI, CON I CORRISPONDENTI
CODICI, PER LE QUALI È VALIDA LA PATENTE

Codice della categoria / PK-Kategorie	Icona	Codice della categoria / PK-Kategorie	Icona
A		A1	
B		B1	
C		C1	
D		D1	
BE			
CE		C1E	
DE		D1E	

RESTRIZIONI DELLA LICENZA

12. Дотор тал /хасалтын мэдээлэл/

EXCLUSIONS

Le dichiara esplicito dei diritti di condurre nei le categorie di

A Design
 E Le

EXCLUSIONS

Le dichiara esplicito dei diritti di condurre nei le categorie di

A Design
 E Le

EXCLUSIONS

Le dichiara esplicito dei diritti di condurre nei le categorie di

A Design
 E Le

EXCLUSIONS


Le dichiara esplicito dei diritti di condurre nei le categorie di

A Design
 E Le

13. Дотор тал /эзэмшигчийн мэдээлэл/

1. _____
 2. _____
 3. _____
 4. _____
 5. _____

Group	Group
A	AI
B	BI
C	CI
D	DI
BE	
CE	CIE
DE	DIE



Photo

Signature of the holder

REMARKS:
 The holder is deprived of the right to drive in the territory of _____ and _____
 At _____ on _____

The holder is deprived of the right to drive in the territory of _____ and _____
 At _____ on _____

14. Гадна талын хавтас

Монгол Улсын олон улсын жолоочийн үнэмлэхийн загварын мэдээлэл

Монгол Улсын олон улсын жолоочийн үнэмлэхийн загвар, нууцлалын тухай мэдээлэл нь цаасан хэлбэртэй, манай улсын нэгдэн орсон “Замын хөдөлгөөний тухай болон Замын дохио, тэмдгийн тухай” 1968 оны Венийн Конвенцийн дагуу А6 (148x105 mm) форматын хэмжээтэй дэвтэр байна. Мөн гадна тал нь сайжруулсан цаасан дээр бүрэлттэй, алтлаг клишетэй, товгор бичиглэл бүхий хавтастай 7 хуудас, 14 нүүртэй, дотор хэсэгтээ Монгол, Англи, Франц, Орос, Герман, Итали хэл дээр орчуулагдсан, Венийн Конвенцийн гишүүн орнуудын жагсаалтыг агуулсан байна.

Олон улсын жолоочийн үнэмлэх дээр хэвлэгдэх мэдээлэл

1. Үнэмлэхийн эхний нүүрэнд батлагдсан загварын дагуу олон улсын жолоочийн үнэмлэхийн дугаар, хүчинтэй хугацаа, олгосон байгууллага, олгосон огноо, жолоочийн үнэмлэхийн дугаарыг гараар гаргацтай тод бичих ба үнэмлэх олгосон албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тэмдгээр баталгаажуулах;

2. Хоёр болон дөрөв дэх нүүрэнд Монгол болон Англи хэлээр Венийн Конвенцийн хамаарал бүхий заалт, хүчинтэй орны нэрсийн жагсаалт;

3. Зургаагаас арав дахь нүүрэнд Англи, Франц, Орос, Герман, Итали хэл дээр эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, төрсөн огноо, газар, тээврийн хэрэгсэл жолоодох зөвшөөрөгдсөн ангилал, дэд ангиллын тэмдэглэл, хүлээн зөвшөөрсөн улсаас тээврийн хэрэгсэл ашиглалттай холбоотой бусад хязгаарлалтын тэмдэглэл;

4. Арваннэгдүгээр нүүрэнд хүлээн зөвшөөрсөн улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хязгаарласан тэмдэглэл;

5. Арванхоёрдугаар нүүрэнд эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, төрсөн огноо, газар, тээврийн хэрэгсэл жолоодох зөвшөөрөгдсөн ангилал, дэд ангиллын тэмдэглэл, эзэмшигчийн зураг, эзэмшигчийн гарын үсэг зэргийг тусгаж, эзэмшигчийн фото зураг дээр цагдаагийн бэлгэдэл (галаграм)-ийг наана.

--oOo--


Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН "ЖОЛООЧИЙН ТҮР ЗӨВШӨӨРЛИЙН" ЭХ ЗАГВАР, НУУЦЛАЛ

А. Нүүрэн тал



Б. Ар тал



В. Бүтэц, зохион байгуулалт



Жолоочийн түр зөвшөөрлийн загвар

Тээврийн хэрэгслийн жолоочийн түр зөвшөөрөл нь 90×60 mm хэмжээтэй чанарын шаардлага хангасан фото цаасан дээр хэвлэгдэнэ.

Жолоочийн түр зөвшөөрлийн дэвсгэр нь жолоочийн үнэмлэхийн ижил өнгөтэй, төвөөс цацарсан хэлбэртэй усан хээтэй, нүүрэн талын голд “Бадамлянхуа цэцэг”-ийн суурин дээр “Төрийн соёмбо”-той, дээд талд “Түр зөвшөөрөл” гэсэн Монгол хэлээр, баруун талд “Жолоочийн түр зөвшөөрөл” гэсэн Уйгаржин Монгол бичиглэлтэй байна.

Жолоочийн түр зөвшөөрөл дээр хэвлэгдэх мэдээлэл

Монгол Улсын нэгдэн орсон “Замын хөдөлгөөний тухай болон Замын дохио, тэмдгийн тухай” 1968 оны Венийн Конвенцийн дагуу дараах дугаарлалтаар мэдээллийг тусгана.

- 1.Эцэг (эх)-ийн нэр;
- 2.Өөрийн нэр;
- 3.Төрсөн огноо;
- 4.(a) Үнэмлэх олгосон огноо;
- 4.(b) Үнэмлэхийн хүчинтэй огноо;
- 4.(c) Үнэмлэх олгосон байгууллагын нэр;
- 5.Үнэмлэхийн дугаар;
- 6.Эзэмшигчийн зураг;
- 7.Эзэмшигчийн гарын үсэг;
- 9.Тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн ангилал ба дэд ангилал;
- 10.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) тус бүрийн эрх олгосон огноо;
- 12.Тээврийн хэрэгслийн ангилал (дэд ангилал) бүрт хамаарах нэмэлт мэдээлэл буюу хязгаарлалт зэрэг мэдээллийг Монгол, Англи хэл дээр тайлбарын хамт хэвлэнэ.

Нууцлал болон бусад мэдээлэл

Жолоочийн түр зөвшөөрлийн зүүн дээд өнцөгт Монгол Улсын “Төрийн далбаа”, баруун доод өнцөгт цэнхэр өнгийн дүрсэнд “MGL” гэсэн ялгах тэмдэг, ар талын баруун хэсэгт жолоочийн үнэмлэхэд агуулагдах мэдээллийн тайлбарыг Англи, Монгол хэлээр бичиж, нүүрэн талд олон улсын QR code ашиглан цахим хэлбэрээр шалгах хаягийг тус тус тусгана.

Нүүрэн талд “Монгол Улсын нутаг дэвсгэрт үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийн нэгэн адил хүчин төгөлдөр тээврийн хэрэгсэл жолоодох эрх зүйн баримт бичиг болно.”, “түр зөвшөөрөл олгосноос хойш 3 сарын хугацаанд хүчинтэй.” гэсэн улаан өнгийн бичиглэлтэй, ар талын санамж хэсэгт жолоочийн түр зөвшөөрлийг баталсан журам, бусад санамжууд байрлана.

Нэг.Монгол Улсын жолоочийн үнэмлэхэд ангилал, дэд ангилалд хамаарах нэмэлт мэдээллийг дараах байдлаар тусгана.

1.1.Хараа зүйн онцлогтой; (Өнгөний харалган согогтой жолоочийн талаарх нэмэлт мэдээлэл) (бүх ангилал)

1.2.Сонсголын бэрхшээлтэй; (Сонсголын төхөөрөмжийн тусламжтай хүрээлэн буй орчны чимээг сонсох чадамжгүй хүний мэдээлэл) (бүх ангилал)

1.3.Тулгуур эрхтний бэрхшээлтэй; (Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй гарны хүчээр ажиллах тээврийн хэрэгсэл жолоодох хүний мэдээлэл) (бүх ангилал)

1.4.Биеийн дээд хэсгийн протезтой буюу хөгжлийн бэрхшээлтэй. (Биеийн дээд хэсэгт протезтой эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэдээлэл) (бүх ангилал)

Хоёр.Монгол Улсын жолоочийн үнэмлэхэд ангилал, дэд ангилалд хамаарах хязгаарлалтыг дараах байдлаар тусгана.

2.1.Ашиг олох зорилгоор том оврын тээврийн хэрэгсэл жолоодох эсхүл нийтийн тээврийн хэрэгсэл жолоодох үед нүдний шил болон контакт линз хэрэглэх; (Эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр нүдний шил, контакт линз хэрэглэх шаардлагатай заалтыг иргэнд хамаарна) (C, C1, CE, C1E, D, D1, DE, D1E ангиллууд)

2.2.Гараар удирдах авцуулах холбоо ашиглах; (Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хамаарна) (бүх ангилал)

2.3.Гар удирдлагатай тоормос ашиглах; (Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хамаарна) (бүх ангилал)

2.4.Гар ажиллагаатай хурдасгуурын дөрөө ашиглах; (Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хамаарна) (бүх ангилал)

2.5.Зөвхөн өдрийн цагаар тээвэрлэлт хийх, нийтийн тээврийн хэрэгсэл жолоодох; (Эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр шөнийн цагаар тээврийн хэрэгсэл жолоодох чадамжгүй болохыг тогтоосон хүнийг үдшийн бүрийгээс үүрийн гэгээ орох хүртэлх хугацаанд тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглоно) (C, C1, CE, C1E, D, D1, DE, D1E ангиллууд)

2.6.Зөвхөн автомат хурдын хайрцагтай тээврийн хэрэгсэл жолоодох. (Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтад автомат хурдны хайрцагтай тээврийн хэрэгслээр дадлага хийлгэж, шалгалт өгсөн тохиолдолд механик хурдны хайрцагтай тээврийн хэрэгсэл жолоодохыг хязгаарлана) (бүх ангилал)